



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 383

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 20 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Хэнтий аймгийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй 12,500,000.00 (арван хоёр сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Золбаяр, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Хэнтий аймгийн газрын захирал О.Од-Эрдэнэ наарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Акталсан хөрөнгийг худалдсанаас олох орлогыг /худалдахтай холбогдон гарсан зардлыг хассан дүнгээр/ компанийд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийн хамт 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮИН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000000

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн  
383 дугаар тогтоолын хавсралт



“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн Хэнтий аймгийн газрын үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ (төгрөг)
1	УАЗ-22069, 51-33 ХЭА, арал №80438791	2007/ 2007	12,500,000.00	1,000,000.00
	Нийт дүн		12,500,000.00 (арван хоёр сая таван зуун мянган)	1,000,000.00 (нэг сая)